

ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Говьсүмбэр аймгийн Баянтал сумын Засаг даргын тамгын 2024 оны санхүүгийн
тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ГСА-2025/003/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Говьсүмбэр аймаг 2025 он</p>	<p>Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор: Б.Сарантуяа Утас: 70543179, Цахим хаяг: sarantuyab@audit.gov.mn Аудитын менежер: Г.Наранбаяр Цахим хаяг: naranbayarg@audit.gov.mn Ахлах аудитор: Г.Ариунцэцэг Цахим хаяг: Ariuntsetsegg@audit.gov.mn</p>
--	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА.....	9
4. АУДИТЫН ТАЙЛАН	18
4.1 Ерөнхий зүйл	18
4.2 Материаллаг байдал	18
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	18
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	19
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	19
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	21
4.5.1 Завсрын аудитын талаар.....	21
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	21
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	22
5.2 Албан шаардлага.....	23
5.3 Зөвлөмж	24
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	25

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
НБББББ	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг
ТШЗ	Төсвийн шууд захирагч
НА	Нийцлийн аудит



**ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

42015 Говьсүмбэр аймаг, Сүмбэр сум, 3 дугаар баг
Утас/Факс: 976-7054 3179
И-мэйл: goviusumber@audit.gov.mn

**БАЯНТАЛ СУМЫН ЗАСАГ
ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ
Ш.ШИНЭБАЯР ТАНАА**

2025.02.25 № 34

танай _____-ны № _____-т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу "Баянтал сумын Засаг даргын тамгын газар"-ын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх тэдгээрийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

1. Сумын Засаг даргын 2024.12.26-ны Б/23 захирамж, ЗДТГ-ын даргын 2024.12.26-ны Б/58 тушаалаар нийт албан хаагчдад үндэслэлгүйгээр үр дүнгийн урамшууллыг давхардуулан хавтгайруулан олгож төсвийн хөрөнгийг арвилан хэмнэлтгүй, үр ашиггүй зарцуулсан. Сумын Засаг даргад үр дүнгийн урамшуулал олгох шийдвэрийг томилох эрх бүхий албан тушаалтан гаргах байтал сумын ЗДТГ-ын дарга урамшуулал олгох тушаал гаргаж, эрх мэдлээ хэтрүүлсэн, тайлант онд орон тоо дутуу ажилласанаас үүссэн цалин хөлсний хэмнэлтийг төсөвт буцаан төвлөрүүлээгүй, 20,030.0 мянган төгрөгийг урамшуулалд давхардуулан олгож, урамшууллын зардлыг хэтрүүлсэн.
2. Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолоор баталсан "Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид нэмэгдэл хөлс олгох журам"-ыг зөрчиж, сард олгох илүү цагийн хэм, хэмжээг хэтрүүлэн албан хаагчдад илүү цагийн нэмэгдэл хөлс олгосон, тайлант онд орон тоо дутуу ажилласанаас үүссэн цалин хөлсний хэмнэлтийг төсөвт буцаан

422502176

төвлөрүүлээгүй, илүү цагийг хэтрүүлэн олгож 3,474.0 мянган төгрөгийн төсвийг арвилан хэмнэлтгүй, үр ашиггүй зарцуулсан.

3. Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам зөрчиж, 11,000.0 мянган төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан. /А/84, А/75 тушаалаар хандив цуглуулах хүлээн авалт/
4. Төрийн хэмнэлтийн тухай хууль зөрчиж 3,000.0 мянган төгрөгөөр хувцас худалдан авсан.
5. Тээвэр шатахууны тайланд 5 дугаар сард анхан шатны баримтын бүрдэлгүй, жолоочийн тооцооны хуудасгүй 266.4 мянган төгрөгийн шатахуун зарцуулсан.

Дээрх зөрчлүүд нь АДБОУС-200-гийн 64-д зааснаар бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаар буюу нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 "Үнэн зөв байх", 13 дугаар зүйлийн 13.1 "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 20 дугаар зүйлийн 20.1.4 "хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх", 20.2.4 "нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах", Сангийн сайдын 2017 оны 347-р тушаалаар батлагдсан маягт, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалын хавсралтын 7 дугаар зүйлийн 7.1-т "Төсвийн захирагч нөөц хөрөнгийн санхүүжилтийг зөвхөн зориулалтын дагуу зарцуулна", Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолоор баталсан "Төрийн захиргааны болон төрийн үйлчилгээний албан хаагчид нэмэгдэл хөлс олгох журам"-ын 3.3-т "Илүү цагаар, долоо хоногийн амралтын өдрөөр, нийтээр амрах баяр ёслолын өдрөөр, шөнийн цагаар ажилласны нэмэгдэл хөлс тооцох цаг нь 4.1-т зааснаас бусад тохиолдолд тухайн сарын ажлын цагийн 10 хувиас хэтрэхгүй байна", Төрийн хэмнэлтийн тухай хууль 8 дугаар зүйлийн 8.1-т "Цэргийн алба хаагч, прокурор, гадаадын иргэний хяналтын улсын байцаагч, гаалийн улсын байцаагчаас бусад албан хаагч төсвийн болон байгууллагын хөрөнгөөр дүрэмт хувцас худалдан авахыг хориглоно" гэж заасныг тус тус зөрчсөн бөгөөд санхүүгийн тайлагналын иж бүрэн байх, үнэн ба зөв байх, эрх ба үүрэг гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Санхүүгийн тайлангийн тухай болон аудитын тайлангийн тухай хэрэглэгчдийн анхаарал хандуулах ач холбогдолтой зүйлийн талаар тодруулахад тус байгууллага нь дүгнэлтийн үндэслэлд дурдсан материаллаг хэмжээний алдаа, зөрчилтэй байна. Байгууллагын удирдлагын зүгээс тавих дотоод хяналт хангалтгүй байгаагаас хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар ажил гүйлгээ бүртгэж, хууль журмыг зөрчсөн урамшуулал, илүү цагийн хөлсийг олгож, ажил гүйлгээ хийсэн байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн

асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Бусад асуудлын хэсэг

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.САРАНТУЯА

2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	199,630,296.45	258,489,796.45
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	-	17,480,000.00
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	-	17,480,000.00
3121	өгрөг	-	17,480,000.00
31218	Ахмадын сангийн харилцах	-	17,480,000.00
33	АВЛАГА	3,368,126.05	3,368,126.05
335	Бусад авлага	3,368,126.05	3,368,126.05
33520	Хувь хүмүүсээс авах авлага	3,368,126.05	3,368,126.05
34	УРЬДЧИЛГАА	218,670.40	218,670.40
3471	Урьдчилгаа тооцоо	218,670.40	218,670.40
34713	Цалингийн урьдчилгаа	218,670.40	218,670.40
35	БАРАА МАТЕРИАЛ	183,578,500.00	210,495,500.00
351	Түүхий эд материал	25,407,080.00	25,407,080.00
35110	Тусгай зориулалттай материал	25,407,080.00	25,407,080.00
354	Хангамжийн материал	158,171,420.00	185,088,420.00
35410	Бичиг хэргийн материал	840,037.00	1,030,037.00
35420	Аж ахуйн материал	20,984,456.00	47,711,456.00
35470	Бусад хангамжийн материал	136,346,927.00	136,346,927.00
36	НӨӨЦИЙН БАРАА	12,465,000.00	26,927,500.00
36300	Тэжээлийн нөөц	12,465,000.00	26,927,500.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,455,184,549.83	2,684,542,582.75
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,455,184,549.83	2,684,542,582.75
392	Биет хөрөнгө	1,376,361,549.83	2,398,292,582.75
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,237,597,661.72	1,471,318,312.72
39202	Хуримтлагдсан элэгдэл	(361,221,953.73)	(331,433,549.09)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	73,318,350.00	57,578,990.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(46,482,743.71)	(32,470,202.07)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	122,660,160.00	129,865,880.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(74,140,006.10)	(52,530,503.05)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	90,776,527.72	50,884,296.82
39208	Хуримтлагдсан элэгдэл	(76,596,192.82)	(20,630,180.34)
39214	Бусад үндсэн хөрөнгө	657,952,240.00	1,391,224,109.80
39215	Хуримтлагдсан элэгдэл	(247,502,493.25)	(265,514,572.04)
393	Биет бус хөрөнгө	78,823,000.00	286,250,000.00
39301	Програм хангамж	2,980,000.00	1,177,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(2,755,000.00)	(925,000.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	78,598,000.00	285,998,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,654,814,846.28	2,943,032,379.20
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	2,893,664.72	-
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	2,893,664.72	-
413	Өглөг	2,893,664.72	-
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	2,893,664.72	-
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,651,921,181.56	2,943,032,379.20
51	Засгийн газрын хувь оролцоо	1,651,921,181.56	2,943,032,379.20
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	753,426,290.17	753,426,290.17
51101	Өмч: - төрийн	753,426,290.17	753,426,290.17
512	Хуримтлагдсан үр дүн	153,123,001.61	1,444,234,199.25
51210	Өмнөх үеийн үр дүн	4,400,276.48	153,771,063.44
51220	Тайлант үеийн үр дүн	148,722,725.13	1,290,463,135.81
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	745,371,889.78	745,371,889.78
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,654,814,846.28	2,943,032,379.20

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,028,491,047.00	2,537,490,242.62
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	318,487,447.00	1,416,020,242.62
120	Нийтлэг татварын бус орлого	318,487,447.00	1,416,020,242.62
120003	Торгуулийн орлого	692,874.00	-
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	274,037,773.00	1,368,358,742.62
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	43,756,800.00	47,661,500.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	710,003,600.00	1,121,470,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	7,017,000.00	28,941,500.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	-	11,400,500.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	17,541,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	7,017,000.00	-
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	702,986,600.00	1,092,528,500.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	702,986,600.00	1,092,528,500.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	845,375,480.83	1,247,027,106.81
21	УРСГАЛ ЗАРДАЛ	845,375,480.83	1,247,027,106.81
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	772,538,759.46	1,170,884,563.40
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	382,564,630.27	594,792,954.79
210101	Үндсэн цалин	252,534,815.66	329,316,925.76
210102	Нэмэгдэл	87,690,441.61	211,366,099.03
210103	Унаа хоолны хөнгөлөлт	6,454,720.00	20,265,000.00
210104	Урамшуулал	35,884,653.00	33,844,930.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	49,488,204.62	72,903,061.91
210201	Тэтгэврийн даатгал	34,108,154.84	49,941,446.67
210202	Тэтгэмжийн даатгал	4,012,724.06	5,888,046.07
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,333,513.67	2,917,623.06
210204	Ажилгүйдлийн даатгал	730,345.53	2,784,896.44
210205	Эрүүл мэндийн даатгал	7,303,466.52	11,371,049.67
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	92,487,337.18	92,000,000.00
210301	Гэрэл, цахилгаан	6,535,947.18	9,072,227.66
210302	Түлш, халаалт	82,163,309.00	80,355,371.94
210303	Цэвэр, бохир ус	3,788,081.00	2,572,400.40
2104	Хангамж, бараа материалын зардал	59,223,001.28	102,685,619.00
210401	Бичиг хэрэг	9,966,900.00	19,380,720.00
210402	Тээвэр, шатахуун	26,758,471.28	49,659,160.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,627,260.00	2,398,409.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	180,000.00	180,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	9,422,120.00	-
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	10,268,250.00	31,067,330.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,520,450.00	1,800,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	440,000.00	-
210604	Урсгал засвар	4,080,450.00	1,800,000.00
2107	Томилолт, зочны зардал	4,742,000.00	10,160,000.00
210702	Дотоод албан томилолт	4,742,000.00	10,160,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	45,188,318.00	47,251,318.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	42,585,000.00	43,433,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	1,478,600.00	1,118,562.00

210804	Тээврийн хэрэгслийн татвар	227,928.00	193,256.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	77,000.00	66,500.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	720,000.00	1,840,000.00
210807	Газрын төлбөр	99,790.00	600,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	134,324,818.11	249,291,609.70
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	9,002,700.00	93,540,900.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	210,000.00	520,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	125,112,118.11	155,230,709.70
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	72,836,721.37	76,142,543.41
2132	Бусад урсгал шилжүүлэг	43,294,800.00	16,946,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	38,630,800.00	-
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	-	15,356,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	4,664,000.00	1,590,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	-	59,196,543.41
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	59,196,543.41
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	29,541,921.37	-
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	29,541,921.37	-
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	183,115,566.17	1,290,463,135.81
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	34,392,841.04	-
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	34,392,841.04	-
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	(34,392,841.04)	-
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	148,722,725.13	1,290,463,135.81

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	710,003,600.00	1,138,950,000.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	-	17,480,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	-	17,480,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	-	17,480,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	17,480,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	710,003,600.00	1,121,470,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	7,017,000.00	28,941,500.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	-	11,400,500.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	17,541,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	7,017,000.00	-
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	702,986,600.00	1,092,528,500.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	702,986,600.00	1,092,528,500.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	707,410,600.00	1,105,240,000.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	634,573,878.63	1,028,188,456.59
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	378,772,545.27	613,614,740.79
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	239,943,635.16	347,664,838.14
210101	Үндсэн цалин	90,120,384.29	212,820,863.76
210102	Нэмэгдэл	6,767,083.00	19,513,266.78
210103	Унаа хоолны хөнгөлөлт	41,941,442.82	33,615,772.11
210104	Урамшуулал		

2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	46,604,924.90	73,806,878.80
210201	Тэтгэврийн даатгал	34,989,352.04	51,247,850.26
210202	Тэтгэмжийн даатгал	3,891,112.94	5,888,146.07
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,319,516.04	2,917,673.06
210204	Ажилгүйдлийн даатгал	491,357.83	2,570,059.74
210205	Эрүүл мэндийн даатгал	4,913,586.05	11,183,149.67
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	95,576,163.18	92,000,000.00
210301	Гэрэл, цахилгаан	6,535,947.18	9,072,227.66
210302	Түлш, халаалт	85,192,559.00	80,355,371.94
210303	Цэвэр, бохир ус	3,847,657.00	2,572,400.40
2104	Хангамж, бараа материалын зардал	19,952,911.28	37,191,919.00
210401	Бичиг хэрэг	4,977,500.00	8,292,120.00
210402	Тээвэр, шатахуун	10,468,001.28	19,457,760.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,627,260.00	2,398,409.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	180,000.00	180,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,700,150.00	6,863,630.00
2105	Нормативт зардал	333,000.00	-
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	333,000.00	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	9,707,000.00	12,883,700.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	2,607,000.00	540,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	1,100,000.00	488,000.00
210604	Урсгал засвар	6,000,000.00	11,855,700.00
2107	Томилолт, зочны зардал	4,742,000.00	10,160,000.00
210702	Дотоод албан томилолт	4,742,000.00	10,160,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	59,467,444.00	69,963,718.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	56,864,126.00	66,145,400.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох		
210803	Даатгалын үйлчилгээ	1,478,600.00	1,118,562.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	227,928.00	193,256.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	77,000.00	66,500.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	720,000.00	1,840,000.00
210807	Газрын төлбөр	99,790.00	600,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	19,417,890.00	118,567,500.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	18,717,890.00	117,747,500.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	700,000.00	820,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	72,836,721.37	77,051,543.41
2132	Бусад урсгал шилжүүлэг	43,294,800.00	17,855,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	38,630,800.00	-
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	-	15,356,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	4,664,000.00	2,499,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	-	59,196,543.41
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	59,196,543.41
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	29,541,921.37	-
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	29,541,921.37	-
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	2,593,000.00	33,710,000.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	2,593,000.00	16,230,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	2,593,000.00	16,230,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	2,593,000.00	16,230,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	2,593,000.00	16,230,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(2,593,000.00)	(16,230,000.00)

8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	17,480,000.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	17,480,000.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан /төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2016 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	753,426,290.17	745,371,889.78	4,400,276.48	1,503,198,456.43
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	753,426,290.17	745,371,889.78	4,400,276.48	1,503,198,456.43
C07	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	148,722,725.13	148,722,725.13
C08	2016 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	753,426,290.17	745,371,889.78	153,123,001.61	1,651,921,181.56
D01	2017 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	753,426,290.17	745,371,889.78	153,123,001.61	1,651,921,181.56
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	648,061.83	648,061.83
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	753,426,290.17	745,371,889.78	153,771,063.44	1,652,569,243.39
D08	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	1,290,463,135.81	1,290,463,135.81
D09	2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	753,426,290.17	745,371,889.78	1,444,234,199.25	2,943,032,379.20

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан /төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл			
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,092,528,500.00	1,033,331,956.59	59,196,543.41
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,092,528,500.00	1,033,331,956.59	59,196,543.41
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,076,596,600.00	1,030,832,956.59	45,763,643.41
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	651,232,100.00	613,614,740.79	37,617,359.21
210101	Үндсэн цалин	310,720,000.00	347,664,838.14	-36,944,838.14
210102	Нэмэгдэл	268,812,100.00	212,820,863.76	55,991,236.24
210103	Унаа хоолны хөнгөлөлт	30,300,000.00	19,513,266.78	10,786,733.22
210104	Урамшуулал	41,400,000.00	33,615,772.11	7,784,227.89
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	81,415,000.00	73,806,878.80	7,608,121.20
210201	Тэтгэврийн даатгал	56,615,000.00	51,247,850.26	5,367,149.74
210202	Тэтгэмжийн даатгал	6,240,000.00	5,888,146.07	351,853.93
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,990,000.00	2,917,673.06	2,072,326.94
210204	Ажилгүйдлийн даатгал	1,260,000.00	2,570,059.74	- 1,310,059.74

210205	Эрүүл мэндийн даатгал	12,310,000.00	11,183,149.67	1,126,850.33
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	92,000,000.00	92,000,000.00	-
210301	Гэрэл, цахилгаан	8,000,000.00	9,072,227.66	- 1,072,227.66
210302	Түлш, халаалт	79,000,000.00	80,355,371.94	- 1,355,371.94
210303	Цэвэр, бохир ус	5,000,000.00	2,572,400.40	2,427,599.60
2104	Хангамж, бараа материалын зардал	36,667,000.00	36,666,919.00	81.00
210401	Бичиг хэрэг	7,117,000.00	7,767,120.00	- 650,120.00
210402	Тээвэр, шатахуун	21,250,000.00	19,457,760.00	1,792,240.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	6,000,000.00	2,398,409.00	3,601,591.00
210404	Ном, хэвлэл	500,000.00	-	500,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	200,000.00	180,000.00	20,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,600,000.00	6,863,630.00	- 5,263,630.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	23,114,000.00	23,113,700.00	300.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	10,614,000.00	10,270,000.00	344,000.00
210602	Тавилга	500,000.00	500,000.00	-
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	1,000,000.00	488,000.00	512,000.00
210604	Урсгал засвар	11,000,000.00	11,855,700.00	- 855,700.00
2107	Томилолт, зочны зардал	9,500,000.00	9,500,000.00	-
210702	Дотоод албан томилолт	9,500,000.00	9,500,000.00	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	74,097,200.00	73,963,718.00	133,482.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	66,767,000.00	66,645,400.00	121,600.00
210803	Даатгалын үйлчилгээ	1,119,000.00	1,118,562.00	438.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	194,000.00	193,256.00	744.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	77,000.00	66,500.00	10,500.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	5,340,200.00	5,340,000.00	200.00
210807	Газрын төлбөр	600,000.00	600,000.00	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	108,571,300.00	108,167,000.00	404,300.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	107,551,300.00	107,347,000.00	204,300.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,020,000.00	820,000.00	200,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	15,931,900.00	2,499,000.00	13,432,900.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	15,931,900.00	2,499,000.00	13,432,900.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	13,431,900.00	-	13,431,900.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,500,000.00	2,499,000.00	1,000.00

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	28,941,500.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	28,941,500.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	13,585,500.00
2104	Хангамж, бараа материалын зардал	525,000.00
210401	Бичиг хэрэг	525,000.00
2107	Томилолт, зочны зардал	660,000.00
210702	Дотоод албан томилолт	660,000.00

2109	Бараа үйлчилгээний бусад зардал	12,400,500.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	12,400,500.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	15,356,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	15,356,000.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	15,356,000.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	28,941,500.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	28,941,500.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	11,400,500.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	17,541,000.00

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Говьсүмбэр аймгийн Баянтал сумын Засаг даргын тамгын газар нь 2024 онд гүйцэтгэлийн төлөвлөгөөндөө 3 зорилт 149 арга хэмжээг тусгаж Баянтал сумын Засаг даргаар батлуулсан бөгөөд жилийн эцсийн байдлаар 79.7 хувьтай дүгнэгдсэн байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна.

Тайлант хугацаанд Засаг даргын тамгын газрын даргаар Ш.Шинэбаярыг сумын Засаг даргын 2024 оны 08 дугаар сарын 30-ны өдрийн Б/12 дугаартай захирамжаар томилсон байна. Нягтлан бодогчоор хүүхэд асрах чөлөөтэй байсан Х.Ариунгуа нь сумын Засаг даргын тамгын газрын 2024 оны 07 дугаар сарын 31-ний өдрийн Б/28 тушаалаар томилогдон ажиллаж байна.

Тайлант онд дээд шатны төсвийн захирагчийн зүгээс дотоод аудитын хяналт, шалгалт хийгдээгүй дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Говьсүмбэр аймгийн Баянтал сумын Засаг даргын тамгын газрын 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн, хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

Тайлант хугацаанд Баянтал сумын Засаг даргын тамгын газрын даргын 2024 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн А/25 дугаар тушаалаар НБББББ-г шинэчлэн баталсан байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Говьсүмбэр аймгийн Баянтал сумын Засаг даргын тамгын газрын 2024 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан "Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 1,288,2 мянган төгрөгөөр нэмэгдсэн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт /мянган төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Зөрүү
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	-	17,480.0	17,480.0
33	АВЛАГА	3,368.1	3,368.1	-
34	УРЬДЧИЛГАА	218.6	218.6	-
35	БАРАА МАТЕРИАЛ	183,578.5	210,495.5	26,917.0
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,455,184.5	2,684,542.5	1,229,358.0
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,654,814.8	2,943,032.3	1,288,217.5
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	2,893.6	-	- 2,893.6
51	Засгийн газрын хувь оролцоо	1,651,921.1	2,943,032.3	1,291,111.1
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,654,814.8	2,943,032.3	1,288,217.5

Дээрх хүснэгтээс харахад дараах нөлөө бүхий дансанд материаллаг хэмжээний өөрчлөлт гарсан байна: Үүнд:

- Мөнгөн хөрөнгийн данс 17,480.0 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь ахмадын санд 17,480.0 мянган төгрөг төвлөрүүлсэн байна.
- Бараа материал данс 26,917.0 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь 111,695.2 мянган төгрөгийн бараа материалыг төсвийн хөрөнгөөр худалдан авч, 47,661.5 мянган төгрөгийн бараа материалыг үнэ төлбөргүй хүлээн авч, 117,977.2 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулнаас шалтгаалжээ.
- Үндсэн хөрөнгө данс 1,229,358.0 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь 1,384,588.7 мянган төгрөгийн хөрөнгө бүртгэж 260,425.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг данснаас акталж хассан, 703,504.0 мянган төгрөгийн элэгдлийн зардал бүртгэсэнтэй холбоотой байна.
- Өр төлбөрийн данс 2,893.6 мянган төгрөгөөр буурсан нь өмнөх оны НДШ-н өглөгийг барагдуулсантай холбоотой байна.
- Эздийн өмчийн данс нь 1,291,111.1 мянган төгрөгөөр өссөн нь тайлант оны үр дүнтэй холбоотой байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2024 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг орон нутгийн төсвөөс 1,034,188.7 мянган төгрөгөөр нийт зарлагыг 1,034,188.7 мянган төгрөгөөр тооцон төлөвлөсөн байна.

Тайлант онд 4 удаа тодотгол хийж санхүүжилтийг нийт 58,339.8 мянган төгрөгөөр нэмэгдүүлж, 1,092,528.5 мянган төгрөг болгож тодотгосон байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 7 арга хэмжээг санхүүжүүлэхээр 1,092,528.5 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,033,331.9 мянган төгрөг буюу 94.6 хувьтай байгаа нь төсвийг 59,196.6 мянган төгрөгөөр дутуу зарцуулсантай холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/					
Д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	70106-80101	831,840.3	797,726.1	34,114.2	95.9%
2	70106-80106	89,005.0	77,672.4	11,332.6	87.3%
3	70106-80205	1,700.0	1,700.0	-	100%
4	70106-80802	15,931.9	2,499.0	13,432.9	15.7 %
5	70106-81102	94,851.3	94,647.0	204.3	99.8 %
6	70106-81701	9,200.0	9,200.0	-	100%
7	70106-82212	50,000.0	49,887.4	112.6	99.8 %
Нийт		1,092,528.5	1,033,331.9	59,196.6	94.6%

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

Үндсэн үйл ажиллагааны дансны үлдэгдэл 34,114.2 мянган төгрөг байгаа нь цалин, НДШ-ийн зардлаас 33,902.4 мянган төгрөг, бусад зардлаас 211.8 мянган төгрөг хэмнэсэн, баг хорооны үйл ажиллагааны зардлаас 11,332.6 мянган төгрөг, ажил олгогчоос олгох тэтгэмж урамшууллын зардлаас 13,432.9 мянган төгрөг, орон нутгийн нөөц хөрөнгийн зардлаас 204.3 мянган төгрөг, хог хаягдлын зардлаас 112.6 мянган төгрөг хэмнэсэн байна.

Санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд хийгдсэн судалгаагаар тус байгууллага нь тайлант онд ахмадын санд 17,480.0 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Тайлант онд зарцуулсан бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр, хураамж /210801/-ийн зардлын 66,645.4 мянга, бараа үйлчилгээний бусад зардал /210901/-ын 107,347.0 мянган төгрөгийг зориулалтын дагуу зарцуулсан байна.

Баянтал сумын Засаг даргын тамгын газарт 2024 онд нийт 20 орон тоо батлагдсан байна. Үүнээс 17 орон тоо бүтэн ажилласан бол хөдөө аж ахуйн мэргэжилтэн 1, төрийн сангийн мэргэжилтэн 1, байгаль хамгаалагч 1 орон тоо тус тус хавсран гүйцэтгэж ажилласан байна.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т "нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн

гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна" гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тус байгууллага нь нэмэлт санхүүжилтийн дансанд тайлант онд нийт 28,941.5 мянган төгрөгийг хүлээн авч зориулалтын дагуу зарцуулсан байна.

3.5.4 Төсөл, хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тайлант онд хэрэгжүүлсэн төсөл хөтөлбөр байхгүй байна.

3.5.5 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Тайлант онд худалдан авах ажиллагаа зохион байгуулаагүй.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Говьсүмбэр аймгийн Баянтал сумын Засаг даргын тамгын газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Г.Ариунцэцэг гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Г.Наранбаяр, дарга, Тэргүүлэх аудитор Б.Сарантуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Говьсүмбэр аймгийн Говьсүмбэр аймгийн Баянтал сумын Засаг даргын тамгын газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газарт 2025 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 17 дугаартай албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2023 оны нийт зардлын 1.0 хувиар буюу 8,453.7 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70.0 хувиар буюу 5,917.6 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор Монгол Улсын Ерөнхий аудиторын 2022 оны А/59 дүгээр тушаалаар “Төрийн аудитын байгууллагаас Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавих бодлого, чиглэл”, 2022 оны А/89 дүгээр тушаалаар “Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавих бодлого, чиглэлийг хэрэгжүүлэх заавар”-ыг баталсан байна.

Дээрх чиглэл, зааврыг хэрэгжүүлж, санхүүгийн тайлангийн аудитаар шалгагдагч байгууллагад хамааралтай 29 шалгуур үзүүлэлтийн дагуу горим, сорилыг гүйцэтгэж, холбогдох баримтыг тулган баталгаажуулахад дараах зөрчил илэрлээ. Үүнд:

1. Төрийн хэмнэлтийн тухай хууль зөрчиж 11,000.0 мянган төгрөгөөр хувцас худалдан авсан.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хууль 8 дугаар зүйлийн 8.1-т "Цэргийн алба хаагч, прокурор, гадаадын иргэний хяналтын улсын байцаагч, гаалийн улсын байцаагчаас бусад албан хаагч төсвийн болон байгууллагын хөрөнгөөр дүрэмт хувцас худалдан авахыг хориглоно" гэж заасныг зөрчсөн, сахүүгийн тайлангийн эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангаагүй.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг давтан гаргахгүй байх, төсвийн хөрөнгийг хууль журамд нийцүүлэн зарцуулах албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой горим сорилын хүрээнд дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд эхний хагас жилийн санхүүгийн тайлан, хандив тусламжийн орлого, зарлага, 1 удаагийн хөрөнгө зарцуулах шийдвэр, нийт 8 удаагийн мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2-т "хагас жилийн төсвийн гүйцэтгэлийг жил бүрийн 08 дугаар сарын 15-ны өдрийн дотор, өмнөх оны төсвийн гүйцэтгэлийг жил бүрийн 04 дүгээр сарын 25-ны өдрийн дотор, сар, улирлын гүйцэтгэлийг дараа сарын 08-ны өдрийн дотор", 6.3.5-т "хандив, тусламжийн хэмжээ, түүний зарцуулалт", 6.4.8-д "бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр", санхүүгийн тайлангийн иж бүрэн байх батламж мэдэгдлийг хангаж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны цахим хуудсанд мэдээлэл, шийдвэрийг үнэн зөвөөр тухай бүр мэдээлж ажиллах зөвлөмж хүргүүлэв.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хэрэгжилт

Дотоод хяналтын хүрээнд

1. Тайлант хугацаанд жолооч Г.Ганзоригт ээлжийн амралтыг биеэр эдлүүлээгүй.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т "Үнэн зөв байх", Хөдөлмөрийн тухай хуулийн 99 дүгээр зүйлийн 99.1-т "Ажилтанд ажлын жил бүр ээлжийн амралт олгож биеэр эдлүүлнэ" гэж заасныг, санхүүгийн тайлагналын эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангаагүй.

Шийдвэрлэсэн нь: Хууль, тогтоомжийг мөрдөн ажиллаж, амралтын хуваарийн дагуу ажилтан, албан хаагчдын ээлжийн амралтыг биеэр эдлүүлэх зөвлөмж хүргүүлэв.

2. Нягтлан бодогчоор ажиллаж байсан Б.Амартүвшинд 2024.07.03-2024.08.02-ны хооронд ээлжийн амралтын мэдэгдлээр 20 хоногоор ээлжийн амралтыг тооцож олгосон боловч ээлжийн амралтын хугацаа дуусаагүй байхад 2024.07.31-ний Б/27 тоот тушаалаар 07.03-аар ажлаас чөлөөлсөн тушаал гаргаж, хууль эрх зүйн зөрчилтэй шийдвэр гаргасан.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т "Үнэн ба зөв байх", санхүүгийн тайлагналын эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангаагүй.

Шийдвэрлэсэн нь: Ээлжийн амралтыг дууссан хугацаанаас хойш чөлөөлөх, цаашид хууль журамд нийцүүлэн тушаал шийдвэрийг гаргахад анхаарч, алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх зөвлөмж хүргүүлэв.

3. Тайлант онд гамшгаас хамгаалах зардлаас зарцуулсан шатахууны тайланг нэгтгэн тайлагнахдаа анхан шатны баримтын бүрдлийг хангаагүй, архивын нэгжийг бүрэн бүрдүүлээгүй.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т "Үнэн зөв байх", 20 дугаар зүйлийн 20.1.4-т "хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх", санхүүгийн тайлагналын иж бүрэн байх батламж мэдэгдлийг хангаагүй.

Шийдвэрлэсэн нь: Анхан шатны баримтын бүрдлийг хангаж архивын нэгжийг бүрдүүлж ажиллах, цаашид алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх зөвлөмж хүргүүлэв.

Авлагатай холбоотой асуудлын хүрээнд

4. Он удаан жил хуримтлагдсан авлагыг барагдуулах арга хэмжээ авч ажиллаагүй.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.8 "Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-т "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", санхүүгийн тайлагналын эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангаагүй.

Шийдвэрлэсэн нь: Авлага барагдуулах арга хэмжээ авч ажиллах зөвлөмж хүргүүлэв.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Аж ахуйн материалын дансанд 1,183.6 мянган төгрөгийн орлого, зарлагыг материалын нэр төрөл тус бүрээр бүртгээгүй, бөөн дүнгээр бүртгэж тайлагнасныг аудитын явцад залруулсан.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	3	1,350.8	3	1,350.8	100%
Албан шаардлага	7	57,666.7	7	57,666.7	100%
Зөвлөмж	4				
Нийт дүн	14	59,017.5	7	59,017.5	100%

Өмнөх оны аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийг хэрэгжүүлж ажилласан байна.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Санхүүгийн үйл ажиллагаанд хяналт тавих эрх бүхий албан тушаалтан санхүү албаны дарга Л.Отгонпүрэв нь өөрийн нэр дээр банкинд иргэний харилцах данс нээж, сумын 30 жилийн ойн хандив цуглуулсан. Хандивын тайланг эрх бүхий албантушаалтнууд хянаж, баталгаажуулаагүй, Хандивын орлогыг зарцуулах үйл ажиллагаандаа Санхүү албаны дарга нь ашиг сонирхлын зөрчилгүй тухай мэдэгдэл гаргаагүй.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 19,503.6 мянган төгрөгийн 2 алдаа¹ илэрснийг завсрын аудитаар 1,183.6 мянга, аудитын явцад 18,320.0 мянган төгрөгийн 2 алдааг залруулсан.

Залруулсан алдаа: Нийт 6 нэр төрлийн 13 ширхэг 1,183.6 мянган төгрөгийн бараа материалыг нэр төрлөөр задалж аж ахуйн материалын орлого, зарлагаар бүртгэсэн. Шатахууны тайланд илүү бүртгэсэн 600.0 мянган төгрөгийн орлого, бичиг хэрэг, аж ахуйн материалын дасны хооронд үүссэн 100.0 мянган төгрөгийн зөрүү, өвс тэжээлийн тайлангийн эцсийн үлдэгдлийг залруулсан.

Аудитаар нийт 35,884.4 мянган төгрөгийн 5 зөрчил² илэрснээс, 24,040.4 мянган төгрөгийн 3 төлбөрийн акт тогтоож, 11,000.0 мянган төгрөгийн 1 албан шаардлага, 1,114.0 мянган төгрөгийн 1 зөвлөмж өгсөн.

5.1 Төлбөрийн акт

5.1.1 Тайлант оны 5 дугаар сард анхан шатны баримтын бүрдэлгүй, жолоочийн тооцооны хуудасгүй 266.4 мянган төгрөгийн шатахуун зарцуулсан.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т “үнэн зөв байх”, 13 дугаар зүйлийн 13.1-д Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн зөв гаргах үндэслэл болно”, 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно”, 20 дугаар зүйлийн 20.2.3-т “холбогдох олон улсын стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах”, Сангийн сайдын 2017 оны 347-р тушаалаар батлагдсан журмын 3 дугаар зүйлийн 3.6-д “Материалын үнэ бүхий зүйлсийг байгууллагын үйлдвэрлэл, дотоод хэрэгцээнд зарцуулах шаардлага гарсан үед уг зүйлийг авч зарцуулах хүн “Шаардах хуудас”-ыг 1 хувь үйлдэж зөвшөөрөл авна. Эд хариуцагч шаардах хуудсыг үндэслэн материал, үнэ бүхий зүйлийг тавьж олгосны дараа агуулахын бүртгэлд бичилт хийж, тайлант хугацаанд нягтлан бодогчид хүргүүлнэ” санхүүгийн тайлангийн иж бүрэн байх батламж мэдэгдлийг хангаагүй.

Шийдвэрлэсэн нь: Холбогдох хууль, журмыг зөрчиж анхан шатны баримтын бүрдэлгүй зарцуулсан шатахууны зардал болох 266.4 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоов.

5.1.2 Сумын Засаг даргын 2024.12.26-ны Б/23 захирамж, ЗДТГ-ын даргын 2024.12.26-ны Б/58 тушаалаар нийт албан хаагчдад үндэслэлгүйгээр үр дүнгийн урамшууллыг давхардуулан хавтгайруулан олгож төсвийн хөрөнгийг арвилан хэмнэлтгүй, үр ашиггүй зарцуулсан. Сумын Засаг даргад үр дүнгийн урамшуулал олгох шийдвэрийг томилох эрх бүхий албан тушаалтан гаргах байтал сумын ЗДТГ-ын дарга урамшуулал олгох тушаал гаргаж, эрх мэдлээ хэтрүүлсэн, тайлант онд орон тоо дутуу ажилласанаас үүссэн цалин хөлсний хэмнэлтийг төсөвт буцаан

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

төвлөрүүлээгүй, 20,030.0 мянган төгрөгийг урамшуулалд давхардуулан олгож, зардлыг хэтрүүлсэн.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т "Үнэн зөв байх, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.3-т "хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох", санхүүгийн тайлангийн үнэлгээ ба хуваарилалт, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангаагүй.

Шийдвэрлэсэн нь: Илүү олгосон урамшууллын 20,030.0 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоов.

5.1.3 Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолоор баталсан "Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид нэмэгдэл хөлс олгох журам"-ыг зөрчиж, сард олгох илүү цагийн хэм, хэмжээг хэтрүүлэн албан хаагчдад илүү цагийн нэмэгдэл хөлс олгосон, тайлант онд орон тоо дутуу ажилласанаас үүссэн цалин хөлсний хэмнэлтийг төсөвт буцаан төвлөрүүлээгүй, илүү цагийг хэтрүүлэн олгож 3,474.0 мянган төгрөгийн төсвийг арвилан хэмнэлтгүй, үр ашиггүй зарцуулсан

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Хөдөлмөрийн тухай хуулийн 91 дүгээр зүйлийн 91.2-т "Дараах тохиолдолд ажилтныг илүү цагаар ажиллуулж болно, Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар батлагдсан "Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид нэмэгдэл хөлс олгох журам"-ын 1 дүгээр зүйлийн 1.4-т "Хөдөлмөрийн тухай хуульд заасны дагуу дор дурдсанаас бусад тохиолдолд төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийг ажил олгогчийн санаачлагаар илүү цагаар ажиллуулахыг хориглоно", 1.5-д "Дор дурдсанаас бусад тохиолдолд нийтээр амрах баярын болон долоо хоног бүрийн амралтын өдөр ажил олгогчийн санаачлагаар ажиллуулахыг хориглоно", 1.5.1-д " энэ журмын 4.1-4.4-т заасан тохиолдол", 3.3-т "Илүү цагаар, долоо хоногийн амралтын өдрөөр, нийтээр амрах баяр ёслолын өдрөөр, шөнийн цагаар ажилласны нэмэгдэл хөлс тооцох цаг нь 4.1-т зааснаас бусад тохиолдолд тухайн сарын ажлын цагийн 10 хувиас хэтрэхгүй байна", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-т "үр ашигтай байх", 15 дугаар зүйлийн 15.2.6-д "байгууллагын бүтэц, чиг үүргийг оновчтой тодорхойлж, цалин хөлсийг орлого, гүйцэтгэл, үр дүн, үр ашигтай нь уялдуулан олгох" гэж заасныг тус тус зөрчсөн санхүүгийн тайлагналын эрх ба үүрэг батламж мэдэгдэл, үнэн зөв байх батламж мэдэгдлийг хангаагүй.

Шийдвэрлэсэн нь: Арвилан хэмнэлтгүй, давхардуулан олгосон илүү цагийн хөлсийг орон нутгийн төсөвт төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоов.

5.2 Албан шаардлага

5.2.1 Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журмыг зөрчиж, сумын Засаг даргын 2024 оны А/84, А/75 захирамжаар ойн хандив цуглуулах хүлээн авалт хийхэд 11,000.0 мянган төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 "Үнэн зөв байх", Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д "Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалын хавсралтын 7 дугаар зүйлийн 7.1-т "Төсвийн захирагч нөөц хөрөнгийн санхүүжилтийг зөвхөн зориулалтын дагуу зарцуулна" гэж заасныг, санхүүгийн тайлагналын эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангаагүй.

Шийдвэрлэсэн нь: Хууль журмыг мөрдөж ажиллах, алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэв.

5.3 Зөвлөмж

1. Нийгмийн даатгалын тайлантай холбоотой.

Илрүүлэлт: Нийгмийн даатгалын тайланд 2024 оны 01 дүгээр сард жирэмсэн амаржсаны чөлөөтэй байсан албан хаагчид цалин тайлагнасан, тайланг залруулаагүй, авлагад тусгаагүй.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;" Төрийн албаны тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.1-т "Төрийн албан хаагчид хууль болон албан тушаалын тодорхойлолтод заасан чиг үүргээ хэрэгжүүлсний төлөө төрөөс цалин хөлс олгоно", нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т "үнэн зөв байх", Нийгмийн даатгалын шимтгэл төлөтийг тайлагнах, шимтгэлийг нөхөн төлүүлэх журмын 2 дугаар зүйлийн 2.2-т "Ажил олгогч нь төлбөл зохих нийгмийн даатгалын шимтгэлийг цалин хөлс, түүнтэй адилтгах орлогоос Нийгмийн даатгалын ерөнхий хууль /шинэчилсэн найруулга/-ийн 18 дугаар зүйлд заасан хувь хэмжээгээр тооцож, дараах шаардлагыг хангасан тайланг гаргаж баталгаажуулан ирүүлнэ", 2.2.6-д "тайланд даатгуулагчийн төрөл, цалин хөлс, түүнтэй адилтгах орлогын хэмжээ, улсын кодыг үнэн зөв оруулсан байх" гэж заасныг, санхүүгийн тайлагналын эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангаагүй.

Шийдвэрлэсэн нь: Тайланг залруулах, алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх зөвлөмж хүргүүлэв.

Дээрх шийдвэрийн хэрэгжилтийг 2025 оны 11 сарын 20-ны өдрийн дотор, Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5 дахь заалтын дагуу шийдвэрийн хэрэгжилтийн төлөвлөгөөг хуулийн хугацаанд тус тус Төрийн аудитын байгууллагад ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.